




2019 оны 11 дүгээр сарын 18-22

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ


Улсын хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 1002 яаралтай дуудлагыг хүлээн авсан. Эдгээрийн 841(83.9%) хачигт халдвар, 123(12.3%) галзуугийн эрсдэлд өртсөн, 8(0.8) боом, 7(0.7%) тарваган тахал, 4(0.4%) хумхаа, 1(0.1%) ям, 5(0.5%) денги, 10(1.0%) бэтэг, 3(0.3%) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1 Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол

Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 123 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8%-иар нэмэгдсэн байна.




Эпидемиологийн 46 дугаар долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ долоо хоногт Увс аймгийн Улаагом сумаас галзуу өвчний эрсдэлд өртсөн 1 тохиолдол бүртгэгдсэн. Эмнэлэгт хандаж, вакцинд хамрагдаж, хяналтад орсон.




1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 841 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.3%-иар буурсан байна.



Эпидемиологийн 46 дугаар долоо хоногтой харьцуулахад 2 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ долоо хоногт Говь-Алтай, Хөвсгөл аймгийн 2 сумаас хачигт риккетсиозын сэжигтэй онош тодруулах 2 сорьц хүлээн авсан.



2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар ХР-ын 673 сэжигтэй тохиолдлын 135(20.0%), ХБ-ын 76 сэжигтэй тохиолдлын 17(22.3%), ХЭ-ын 91 сэжигтэй тохиолдлын 18(19.7%) нь тархвар судлал, эмнэл зүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан байна.

1.3 Мэрэгч амьтны дуудлага

Энэ долоо хоногт нийслэлийн Нийслэлийн СХД “Эмээлт” АТШН товчооноос ирүүлсэн мэрэгч амьтны (тулам-3, тарвага-11) хоёр удаагийн дуудлаганд үйлчилж, эрсдэлийг тодорхойлохоор лабораторийн шинжилгээ хийв. Сорьц материалыг шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.


Он гарсаар нийслэлийн 5 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ХУД) хэмжээнд нийт 106 удаагийн амьтны дуудлаганд үйлчилсэн байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Олон улсад:

Эбола вирус халдвар:


2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вирус халдварын сэжигтэй тохиолдол 3291 тохиолдол бүртгэгдсэнээс 2193(67%) нь нас барсан байна. Нийт тохиолдлын 1856(56%) нь эмэгтэйчүүд, 930(28%) нь 18-аас доош насны хүүхдүүд эзлэж байна.



Эх сурвалж: ДЭМБ

Шүлхий өвчин:


Өмнөд Африк улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 11 дүгээр сарын 13-нд Лимпопо тосгонд SAT-2 хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчний дэгдэлт бүртгэгдсэн. Нийт 8354 үхэр өртөмхий байснаас 33 үхэр өвчилсөн байна. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Хэл хөхрөх өвчин:

Герман улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 11 дүгээр сарын 07-нд Саарланд тосгоны үхрийн фермд хэл хөхрөх өвчнөөр 1 үхэр өвчилсөн. Дээрх тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Эх сурвалж: ДМАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	- Унгар улс - Jasz Nagykan Szolnok	2019.11.18	2019.11.11	Ойд	1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	- Белги улс - Люксембург	2019.11.18	2019.11.17	Ойд	1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	- Молдав улс - Хинкли тосгон	2019.11.19	2019.11.15	Тодорхойгүй	1 гахай	17 гахай
ДМАЭМБ	- Украин улс - Полтава тосгон	2019.11.19	2019.11.18	Ферм	11 гахай	418 гахай
ДМАЭМБ	- Латви улс - Салдус тосгон	2019.11.20	2019.11.14	Ойд		1 гахай

Эх сурвалж: ДМАЭМБ

Тарваган тахал:

БНХАУ-ын ӨМӨЗО-нд булчирхайн хэлбэрийн тахлын шинэ тохиолдол батлагджээ. Гэсэн хэдий ч орон нутгийн эрүүл мэндийн албанаас дэгдэлтийн эрсдэл бага болохыг мэдээлж байна. Автономит бүсийн эрүүл мэндийн хорооноос 55 настай, эрэгтэй 2019 оны 11 дүгээр сарын 05-нд зэрлэг туулайн мах идсэний дараагаас уг өвчний шинж тэмдэг илэрсэн гэж мэдэгдсэн байна. Булчирхайн хэлбэрийн тахал нь дэлхий даяар түгээмэл тохиолддог хэлбэр бөгөөд ужгирч, уушгинд тархсанаар илүү хүнд хэлбэрийн уушгины хэлбэрт шилждэг болохыг ДЭМБ-аас мэдээлсэн байна.

ӨМӨЗО-ны энэхүү тохиолдолд 2 хүн холбогдож байгаа бөгөөд энэ сарын эхээр батлагдсан байна. Уушгины тахал болох нь тогтоогдсоноос хойш Өвөр Монголын энэ 2 хүнийг нийслэл дэх байгууламжид тусгаарласан болохыг эрүүл мэндийн удирдлагууд тухайн үед мэдэгдэж байсан. Одоогоор Улаанцав аймгийн эмнэлэгт тусгаарлагдан эмчлэгдэж байна. ӨМӨЗО-ны Эрүүл мэндийн хорооноос дээрх хоёр тохиолдолтой холбоотой өөр тохиолдол дахин гараагүй болохыг мэдэгдсэн.

Өвчтөнүүдтэй нийт 28 хүн ойрхон хавьтал болсон бөгөөд тэднийг тусгаарлан, тандалд судалгаа хийж байна. Одоогоор шинж тэмдэг илэрсэн хүн байхгүй.

Хэдийгээр БНХАУ-д тарваган тахлын дэгдэлт ховор бүртгэгддэг ч 2014 онд Юүмин хотын баруун хойд хэсэгт булчирхайн хэлбэрээр нас барсан 1 тохиолдлоос дундад зууны үед тохиосон “Хар үхэл” хэмээх цар тахлын уушгины хэлбэрийн үүсгэгч нянтай ижил байжээ. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой жил дараалсан ган зудын дараагаас Өвөр Монголд мэрэгчид олширсон. Мөн Нидерланд улсын газар нутгийн хэмжээтэй ижил газар нутагт өнгөрсөн зун “Хархны тахал” дэгдэж, 600 сая юан (\$86 сая)-ий гамшиг учруулсан болохыг Шинхуа агентлаг мэдээлжээ.

Эх сурвалж: Reuters.com